



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 04 сарын 15 өдөр

Дугаар А/236

Булган сум

### Гүйцэтгэгчид гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2.1 дэхь заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн IV/26 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан "Сумын эрүүл мэндийн төвийн барилгын засвар (Могод сум)"-ын ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчээр шалгарсан "Барс оргил" ХХК-тай 103,202,978 (нэг зуун гурван сая хоёр зуун хоёр мянга есөн зуун далан найман) төгрөгөөр гэрээ байгуулж, ажлын гүйцэтгэлд холбогдох хууль, тогтоомж, гэрээний дагуу хяналт тавьж, хүлээн авахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Ү.Бямбасүрэн)-д үүрэг болгосугай.

2.Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандартын дагуу гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг "Барс оргил" ХХК-ийн захирал (Б.Мөнхбаяр)-д үүрэг болгосугай.

3.Хөрөнгийг данс бүртгэлд бүртгэж хөрөнгө ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавихыг Могод сумын Засаг дарга (Г.Энхбат)-д үүрэг болгосугай.

4.Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Д.Батцогт)-д зөвшөөрсүгэй

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



Аймгийн Засаг даргын 20.25 оны  
04 дүгээр сарын 15-ны/ний өдрийн  
А/236 дугаар захирамжийн хавсралт

| Д/д | Нөхцөл шаардлага                         | Мөнгөн дүн                                                                                                                         | Хариуцах албан тушаалтан  |
|-----|------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------|
| 1   | 2                                        | 3                                                                                                                                  | 4                         |
| 1   | Магадлашгүй ажил                         | 1,783,347                                                                                                                          | Ү.Бямбасүрэн              |
| 2   | Захиалагчийн техник хяналтын зардал      | 1,783,347                                                                                                                          | Ү.Бямбасүрэн              |
| 3   | Зураг төсөл зохиогчийн хяналтын зардал   | 891,674                                                                                                                            | Ү.Бямбасүрэн              |
| 4   | Инженер хайгуул, зураг төслийн ажлын дүн | 500,000                                                                                                                            | Ү.Бямбасүрэн              |
| 5   | Нормчлолын сан                           | 160,501                                                                                                                            | Ү.Бямбасүрэн              |
| 6   | Ажил гүйцэтгэх хугацаа                   | Хуанлийн 60 хоног                                                                                                                  | Ү.Бямбасүрэн              |
| 7   | Алданги                                  | Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна | Д.Батцогт                 |
| 8   | Чанарын баталгаа                         | Гэрээний үнийн дүнгийн 5 хувь, чанарын баталгааг байршуулах банк, дансыг гэрээнд тусгана.                                          | Д.Батцогт<br>Ү.Бямбасүрэн |
| 9   | Гүйцэтгэлийн баталгаа                    | Гэрээний үнийн дүнгийн 3 хувь                                                                                                      | Д.Батцогт                 |